



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 01 сарын 03 өдөр

Дугаар А/16

Ховд

Халаалтын зардлыг урьдчилан  
санхүүжүүлэх тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 42 дугаар зүйлийн 43.2 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны “Аймгийн 2022 оны төсөв батлах тухай” 05/07 дугаар тогтоолын 12 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Бадамлах дөл ХХК-ийн нүүрс татах ажиллагааны санхүүгийн эх үүсвэрээс шалтгаалан саатаж дулааны үйлдвэрлэл, нийлүүлэлтэд гарсан хүндрэлийг арилгахаар тус компаниас дулаан авдаг байгууллагуудын халаалтын зардлыг урьдчилан тооцож 260 000 000 төгрөгийг баталж олгосугай.

2. Халаалтын урьдчилгаанд олгох 260 000 000 төгрөг /хоёр зуун жаран сая/-ийг аймгийн Засаг даргын Тамгын газрын нэмэлт данснаас урьдчилан санхүүжүүлэхийг Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Энхболд/, Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/ нарт зөвшөөрсүгэй.

3. Халаалтын урьдчилгаанд олгосон 260 000 000 төгрөгийг хариуцагч төсвийн байгууллагуудын батлагдсан халаалтын зардлаас тооцож төвлөрүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/-д, үүссэн тооцоог төсвийн хуваарийн дагуу Санхүү, төрийн сангийн хэлтсийн мэдэгдлийг үндэслэн барагдуулж ажиллахыг холбогдох төсвийн захирагч нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

8400 01 0142  
Zah A/12 Kh